

**“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ”
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Улаанбаатар хот

№03

2024.04.17

Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл

ҮХ-ны хурал 2024.04.17-ны өдөр 11:30-12:30 цагийн хооронд цахимаар зохион байгуулагдав. Цахим хуралд ҮХ-ны гишүүд бүтэн бүрэлдэхүүнээр оролцов.

Хэлэлцсэн нь:

ҮХ-ны дарга М.Үүрийнтуяа: Сайн байцаана уу? Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн хурлаар тендер амжилтгүй үр дүн үзүүлсэн талаар хэлэлцье.

ҮХ-ны нарийн бичиг М.Оюун-Ундрэм: За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие тендерийн нээлтийг 2024.04.16-ны өдрийн 16:00 цагаас нээсэн бөгөөд өгөгдлийн хүснэгт болон, тендерийн урилгыг бэлтгэж, tender.gov.mn цахим сайтаар тендерийг нээсэн.

Тендер зарлагдсан хугацаанд нэг ч хувь хүн, хуулийн этгээдээс ямар ч хүсэлт ирүүлээгүй бөгөөд тендер амжилтгүй болсон. Манай байгууллагын төсөв бага учраас сонирхсон хувь, хүн хуулийн этгээд байхгүй байна. За дахиад зарлах уу эсвэл ингээд амжилтгүй болсон үр дүнгээр нь тендерээ хаах уу? Манай төсөвт өртөг багасаад байгаа болохоор одоо зарлахаар дахиад амжилтгүй болох магадлалтай байна. Хэдүүлээ ярилцаад нэг шийдэл олъё.

Гишүүн П.Гантуяа: Харьцуулалтын аргаар зарлагдаж байгаа тендер шалгартлаа энэ аргаараа л зарлагдана даа хэрвээ төсөв бага байгаа бол больсон ч болно л доо. Гол нь захиалагч тал тендер сонгон шалгаруулалтыг дахин зарлуулах тохиолдолд техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах саналаа өгөх хэрэгтэй. Миний хувьд дахин зарлах нь үр дүнгүй байх магадлалатай. Өмнөх жилийн болон энэ жилийн тендер шалгаруулалтын үр дүнг харахад ингээд хаах зөв байх.

ҮХ-ны дарга М.Үүрийнтуяа: төсөвт өртөг нь бага учраас тендер сонгон шалгаруулалт үр дүн гарахгүй байна. Тэгэхээр захиалагчид энэ тухайгаа тайлбарласан дүгнэлт хүргүүлээд, дахин зарлах эсэх, техникийн шаардлагыг багасгах эсэх шийдвэрийг хуульд заасан үндэслэлээр гаргуулах нь зөв гэж үзэж байна. Та бүхэн дэмжиж байна уу

Гишүүд: Тэр нь дээр байх. Дэмжиж байна.


ҮХ-ны дарга М.Үүрийнтуяа: нарийн бичиг та дүгнэлтээ гаргаад гишүүдээрээ баталгаажуулаад Захиалагчид хүргүүлээрэй.

ҮХ-ны нарийн бичиг М.Оюун-Ундрэм: за ойлголоо. Та бүхэнд баярлалаа.


Шийдвэрлэсэн нь:

Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул тендер шалгаруулалтыг амжилтгүй болсон гэж үзээд Захиалагч байгууллагад үнэлгээний хорооны дүгнэлтийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хурал 2024.04.17-ны өдрийн 12:30 цагт өндөрлөв.

Үнэлгээний хорооны дарга М.Үүрийнтуяа 

Гишүүд:

П. Гантуяа: 

ҮХ-ны нарийн бичиг М.Оюун-Ундрал: 